




БАТЛАВ,  
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


  
Б.МӨНХБАТ  
  
5022050763  
5081082-СБТ10869

**АЖЛЫН ГУТАЛНЫ ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ / 5 ХУУДАС /**

ТАНИЛЦСАН:  Д.МЯНГАНБААТАР  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЗАХИРАЛ

 Ц.ОДХҮҮ  
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:  А. ЭНХБУЛАГ  
/ХАБЭАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН/

БОЛОВСРУУЛСАН:  Б.СОЛОНГО  
/ХАБЭАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН/

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Тендерт оролцогч нь тусгай зориулалтын ажлын гутал нийлүүлэхдээ МХС ХХК-ийн **“Тусгай зориулалтын ажлын гутал нийлүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага”**-ыг мөрдлөг болгоно.
2. Тендерт оролцогч нь дараах нэр бүхий тусгай зориулалтын ажлын гутлыг нийлүүлнэ.

Үүнд:

- Тусгай зориулалтын зуны ажлын гутал
- Тусгай зориулалтын өвлийн ажлын гутал
- Ажлын шаахай

3. 2024 онд МХС ХХК-д шаардлагатай тусгай зориулалтын ажлын гутлын тоог хүснэгтээр харуулав. /Хүснэгт 1/
4. Тусгай зориулалтын ажлын гутлыг 1 жилийн хугацаанд захиалагчтай тохирсон хуваарийн дагуу нийлүүлэх ба тусгай зориулалтын зуны ажлын гутлыг 5 сарын 15-ны дотор, тусгай зориулалтын өвлийн ажлын гутлыг 10 сарын 15-ны дотор тус тус нийлүүлнэ.
5. Дэлгэрэнгүй шаардлагыг **“Тусгай зориулалтын ажлын гутал нийлүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага”**-аас харна.

Тусгай зориулалтын ажлын гутлын нэр төрөл, тоо хэмжээ

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ /хос/
1	Тусгай зориулалтын зуны ажлын гутал	381
2	Тусгай зориулалтын өвлийн ажлын гутал	375
3	Ажлын шаахай	74

## ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН ГУТАЛ НИЙЛҮҮЛЭХЭД

### ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. **ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН ГУТАЛ** нь MNS 5623:2006 стандартын шаардлагыг хангасан байна.
- 1.1 Ажилтнуудын ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалж тусгай зориулалтын гуталд тавигдах шаардлага болон стандартууд өөр өөр байж болно. Хүснэгт 1-т үзүүлэв.
- 1.2 Ажлын тусгай хувцсаар хангах ангиллын **I хэсгийн А, Б, В, Г ангилалд** хамрагдах ажилтнуудын тусгай зориулалтын ажлын гутал нь ажил гүйцэтгэх үед болзошгүй бэртэл гэмтлээс хамгаалах, үйлдвэрийн орчин нөхцөлд тохирсон, хөлд эвтэйхэн, чийг татдаггүй, хальтирдаггүй байна.
- 1.3 Тусгай зориулалтын ажлын гутал нь цахилгаан гүйдэл дамжуулдаггүй, ус болон тостой, эсвэл төрөл бүрийн химийн бодис ба шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй байна.
- 1.4 Ажлын тусгай хувцсаар хангах ангиллын **II, III, IV, V хэсэгт** хамрагдах ажилтнуудад олгогдох ажлын шаахай нь хальтардаггүй зөөлөн ултай, чийг татдаггүй материалаар хийгдсэн, өндөр өсгийгүй байна.

*1-р хүснэгт*

д/д	Ажлын тусгай хувцсаар хангах хэсэг	Хамаарах албан тушаалтан
I	I хэсэг А	Худаг сувагчлал кабелийн байгууламжийн техникч, сувагчин,
	I хэсэг Б	Ерөнхий инженер, ахлах инженер, ашиглалтын менежер, дамжуулах байгууламжийн инженер, сүлжээний инженер, цахилгаан зай тэжээлийн инженер, хөргөлтийн ИТА, технологийн автомашины жолооч кабель шугамын инженер, ЦТМ, тоо бүртгэлийн техникч, КШТ ахлах инженер, КШИ, хяналтын инженер, худаг сувгийн инженер, шилэн кабелийн инженер, хэмжүүрийн инженер, техникч, дамжуулах системийн инженер, шилэн кабелийн засварын инженер, дотоод сүлжээний хэлтсийн засварын ИТА, наран төвийн засварын ИТА, системийн инженер, РРС-ын засварын инженер, ашиглалтын менежер, автын хэсгийн ажилтан, сантехникийн инженер, слесарь, мужаан, автын механик, автын хэсгийн жолооч, ээлжийн ЦТМ, ЦТМ сахиул, сахиул
	I хэсэг В	ДСАГ-ын эд хариуцагч, эд хариуцагч-бичиг хэрэг, харуул, сахиул, гэрээт ажилтан
	I хэсэг Г	Гүйцэтгэх захирал, газрын захирал, ашиглалтын газрын дарга,, ХАБЭАХ-ийн мэргэжилтэнгүүд, байр ашиглалт хариуцсан ажилтан, УБХСАГ-н хяналтын инженер, ажилтан, автомеханик, жолооч, өгөгдлийн сүлжээний харилцан холболтын инженер
II	II хэсэг	Өгөгдлийн сүлжээний инженер, ээлжийн ахлагч инженер, ээлжийн инженер, техникч, кроссын техникч, архивын ажилтан
III	III хэсэг	Үйлчлэгч
IV	IV хэсэг	Тогооч
V	V хэсэг	Жижүүр

## **2. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ЗУНЫ АЖЛЫН ГУТАЛД тавигдах ерөнхий шаардлага**

- 2.1 Тусгай зориулалтын ажлын гутал нь MNS 5623:2006 /ажлын гутланд тавигдах ерөнхий шаардлага/-ийг хангасан байна.
- 2.2 Ажилтнуудын тусгай зориулалтын ажлын гутал нь өмсөхөд хөлд эвтэйхэн байна.
- 2.3 Ул болон ар хэсэг нь механик биетээс хамгаалах хамгаалалттай байна.
- 2.4 Өнгө үзэмжтэй, бат бөх, давхар оёдолтой, хурууны хамгаалалттай, ул тусгаарлагчтай, хүний арьсанд хүрэх хэсгүүд нь зөөлөн ширээр хийсэн, шагай хамгаалагч зөөлөвчтэй, төмөр тоноглолууд нь зэвэрдэггүй, үртэс, тоос шороо орохооргүй үргэлж хэлтэй, зуузайны хатуулгатай байна.
- 2.5 Ус чийг, халуун хүйтэн, цахилгаан, химийн бодисоос хамгаалахаар зориулалтын материалаар хийгдсэн, хальтирдаггүй ултай байна.
- 2.6 Ажилтнуудын ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалж, тусгай зориулалтын ажлын гуталд тавигдах шаардлага өөр өөр байж болно.

## **3. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ӨВЛИЙН АЖЛЫН ГУТАЛД тавигдах ерөнхий шаардлага**

- 3.1 Тусгай зориулалтын өвлийн ажлын гутал нь түрийтэй болон хагас түрийтэй байна.
- 3.2 Бүтэн нэхий дотортой байх ба эсгий улавчтай байна.
- 3.3 Тусгай зориулалтын өвлийн ажлын гутал нь урд хэсэгтээ үдээстэй байна.
- 3.4 Хүйтэнд болон цас чийгэнд тэсвэртэй, арьс, ширэн материалаар хийгдсэн байна.
- 3.5 Гутлын ул хөлдөхгүй хагарахгүй байна.
- 3.6 Улны материал ямар ч гадаргуу дээр хальтирдаггүй байна.
- 3.7 Өсгий хэсэгт 3 см доошгүй ултай зузаан байна.

## **4. АЖЛЫН ШААХАЙД тавигдах ерөнхий шаардлага**

- 4.1 Ажлын шаахай нь хальтардаггүй, дуу чимээ гаргахгүй зөөлөн үргэлж ултай байна.
- 4.2 Ажлын шаахай нь чийг татдаггүй материалаар хийгдсэн байна.
- 4.3 Ул нь 2см-ээс доошгүй зузаан байна.

## **5. БАГЛАА, БООДОЛД тавигдах шаардлага**

- 5.1 Гутал тус бүрийг хосоор нь размер тус бүрээр савлан хэд хэдээр нь багцалж хайрцаглана.
- 5.2 Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр хаяг, огноог бичсэн дагалдах хуудастай байна. Дагалдах хуудсыг 2 хувь бичиж 1 хувийг өгнө.

5.3 Хайрцагны хажуу талд ус, чийгнээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.